



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

18080 Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг,

Үйлдвэрчний эвлэлийн гудамж 37,

Утас: 7018 1208, Факс: (976) 7018 1467

2015.09.23 № 8-1064

танай _____-ны № _____-т


Мэдээлэл хүргүүлэх тухай

Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын зөвлөлийн дарга, Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн баталсан “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын стандартын дагуу баталгаажуулалтанд бэлтгэх ажлын төлөвлөгөө”-ний 2.2 дугаар заалт (Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын стандартын 3 дугаар шаардлагын 3.9 дэх заалт)-ын хэрэгжилтийг хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт- 11 хуудастай.

ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮ, ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Б. ОЮУН

00023544

**ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ХАЙГУУЛЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ Т А Н И Ц У У Л Г А**

Өнөөгийн байдлаар газрын тосны хайгуулын, ашиглалтын 24 талбайд Засгийн газрын баталсан Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-ний дагуу гадаад, дотоодын гэрээлэгч компаниуд газрын тостой холбогдсон үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

дд	БХГ-т талбайн нэр	БХГ батлагдсан огноо, ЗГ-ын тогтоол	БХГ-ний эрх, үүргийг эзэмшигч компани	Тусгай зөвшөөрөл олгосон компани	Хөрөнгө оруулагчийн харьяалал
1	Тосон-Уул XIX	1993.04.26, ЗГ-ын 1997 оны №239	PetroChina Daqing Tamsag Mongolia (XIX)	Петрочайна Дачин Тамсаг ХХК	БНХАУ
2	Тамсаг XXI	1996.08.07, ЗГ-ын тогтоол №183	PetroChina Daqing Tamsag Mongolia (XXI)	Петрочайна Дачин Тамсаг ХХК	БНХАУ
3	1997БХГ	1997.02.19, ЗГ-ын тогтоол №47	Dong Sheng Jingtong Petroleum Development Group	Доншен газрын тос Монгол ХХК	БНХАУ
4	Матад XX	2006.07.19, ЗГ-ын тогтоол №170	Petromatad Invest Limited	ПетроМатад ХХК	Монгол улс
5	Тариач XV	2007.03.07, ЗГ-ын тогтоол №47	China Golden Sea Petroleum Investment	Голден Сий Петролиум ХХК	БНХАУ
6	Зүүнбаян XIV	2009.05.20, ЗГ-ын тогтоол №148	DWM Petroleum AG	Гоби энержи партнерс ХХК	Швейцарь улс
7	Цагаан-элс XIII	2009.05.20, ЗГ-ын тогтоол №148	DWM Petroleum AG	Гоби энержи партнерс ГмбХ ХХК	Швейцарь улс
8	Галба XI	2009.05.20, ЗГ-ын тогтоол №147	Zong Heng You Tian Limited	Зон Хэн Юу Тиан ХХК	БНХАУ
9	Сулинхээр XXIII	2009.07.22, ЗГ-ын тогтоол №224	Шунхлай Энержи ХХК	Шунхлай Энержи ХХК	Монгол улс
10	Нялга XVI	2007.06.20, ЗГ-ын тогтоол №148	Pan Asian Energy Ltd	Шейман ХХК	Канад
11	Борзон VII	2009.07.29, ЗГ-ын тогтоол №236	Импайр Газ ХХК	Импайр Газ ХХК	БНХАУ
12	Хөхнуур XVIII	2009.07.29, ЗГ-ын тогтоол №238	Эн Пи Ай ХХК	Эн Пи Ай ХХК	БНХАУ
13	Төхөм X (хойд)	2009.07.29, ЗГ-ын тогтоол №237	Сансарын геологи хайгуул ХХК	Сансарын геологи хайгуул ХХК	БНХАУ
14	Цайдам XXVI	2009.07.29, ЗГ-ын тогтоол №237			
15	Богд IV	2009.07.29, ЗГ-ын тогтоол №235	Сентрал азиан петролеум корпорэйшн лимитед	Капкорп монголиа ХХК	Их Британий Каймэний арал улс
16	Онги V	2009.07.29, ЗГ-ын тогтоол №235			
17	Баянтүмэн XVII	2010.12.08, ЗГ-ын тогтоол №316	Магнай трейд ХХК	Магнай трейд ХХК	Монгол улс

18	Дарьганга XXIV	2011.02.09, ЗГ-ын тогтоол №39	Апекспро инвестмент лимитед	Апекспро инвестмент лимитед	БНХАУ
19	Төхөм-Х (урд)	2012.7.25, ЗГ-ын тогтоол №252	МАК корпораци	Монголын алт ХХК	Монгол улс
20	Сүхбаатар-XXVII	2013.01.05, ЗГ-ын тогтоол №02	Вульф Петролеум	Вульф Петролеум	Австрали улс
21	Номгон IX	2014.02.07 ЗГ-ын тогтоол №31	Өмнөд Монголын Газар Нутгийн Тос ХХК	Өмнөд Монголын Газар Нутгийн Тос ХХК	Монгол улс
22	Увс-I	2015.04.20, ЗГ-ын тогтоол №162	Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК	Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК	БНХАУ Хонг Конг
23	Хар-Ус II	2015.06.15, ЗГ-ын тогтоол №246	Ренова Илч ХХК	Тусгай зөвшөөрлөө аваагүй байна	БНХАУ, Хонг Конг
24	Хэрлэнтохой-XXVIII	2015.04.20, ЗГ-ын тогтоол №162	Хонг Конг Вэлпэк Индастриал ХХК	Тусгай зөвшөөрлөө аваагүй байна.	БНХАУ, Хонг Конг

1993-2015 онд газрын тосны хайгуулын 24 талбайд гадаад,дотоодын гэрээлэгч компаниуд Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-ний дагуу газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаагаас Тосон-Уул XIX, талбайн хайгуулын хугацаа 2010.01.30-нд, Тамсаг-XXI талбайн хайгуулын хугацаа 2012.01.30-нд, "1997 оны БХГ"-т талбайн хайгуулын хугацаа 2010.06.14-нд тус тус дуусгавар болж үйлдвэрлэлийн олборлолтонд шилжсэн бөгөөд 21 талбайд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явагдаж байна.

Өнгөрсөн хугацаанд газрын тосны хайгуулын үйл ажиллагаанд 1,5 тэрбум орчим ам. долларын хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Газрын тосны хайгуул, үнэлгээний нөр их ажлын үр дүнгээр Тосон уул, Тамсагийн ордыг нээн илрүүлж, Зүүнбаян, Цагаан элсний ордуудын нөөцийг шинэчлэн тогтоож, дээрх 4 ордын нөөцийн тооцооны тайланг Уул, уурхайн яамны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн хүлээж авсан. Ингэснээр Монгол улс газрын тос олборлогч орон болсон.

Мөн Хөх нуур-ХVIII талбайд өрөмдсөн хайгуулын 4 цооногийн 2 нь тосны шинж тэмдэгтэй, Галба-ХI талбайд өрөмдсөн хайгуулын 14 цооногийн 13 нь тосны илрэлтэй байгаа нь цаашид газрын тосны шинэ ордууд нээгдэх нөхцөлийг бүрдүүлж байгаа юм.

Шинэчлэн найруулсан Газрын тосны тухай хууль 2014 онд УИХ-аар батлагдсан бөгөөд уг хуулийн холбогдох заалтуудын дагуу өмнө нь байгуулагдсан бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг хуульд нийцүүлэн өөрчлөх ажил хийгдэж байна.

Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хийгдэж буй хайгуулын ажлын талаар

Өнөөгийн байдлаар газрын тосны хайгуулын 21 талбайд гадаад, дотоодын гэрээлэгч компаниуд БХГ-ний дагуу газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

д/д	БХГ-т талбайн нэр, Гэрээлэгч компани	БХГ байгуулагдсан огноо	БХГ-ний дагуу хийж гүйцэтгэсэн хайгуулын ажил
1	Матад ХХ Петро Матад инвест лимитед ХХК	2006.07.19	6154 физик цэгт хүндийн хүчний судалгаа, 29944 физик цэгт соронзон хайгуул, 1834.1 тууш.км хоёр хэмжээст, 133.6 км ² талбайд гурван хэмжээст чичирхийллийн судалгаа хийж, хайгуулын 11 цооног өрөмдсөнөөс 6 цооногт тосны шинж тэмдэг илэрч, 5 цооногт туршилт хийсэн боловч үйлдвэрлэлийн агуулгатай нөөц тогтоогдоогүй.
2	Тариач ХV Чайна Голден Сий Петролеум ХХК	2007.03.07	3122 физик цэгт хүндийн хүчний судалгаа, 1761.1 тууш.км хоёр хэмжээст, 446.5 км.кв талбайд гурван хэмжээст чичирхийллийн судалгаа хийж, хайгуулын 21 цооног өрөмдсөнөөс 2 цооногт тос, 3 цооногт тосны шинж тэмдэг, 2 цооногт хий илэрсэн ч үр ашигтай нээлт тогтоогдоогүй.
3	Нялга ХVІ Шэйман ХХК	2007.06.02	787.4 тууш.км хоёр хэмжээст чичирхийллийн судалгаа хийж, хайгуулын 2 цооног өрөмдсөнөөс 1 цооногт тосны шинж тэмдэгтэй.
4	Цагаан-Элс ХІІІ Гоби Энержи Партнерс ХХК	2009.05.20	1779 физик. цэгт хүндийн хүчний, 110 физик. цэгт пассив сейсмийн, 917,7 тууш.км хоёр хэмжээст чичирхийллийн ажил хийж, хайгуулын 2 цооног өрөмдсөн.
5	Зүүнбаян-ХІV Гоби Энержи Партнерс ХХК	2009.05.20	3512 физик. цэгт хүндийн хүчний, 100 физик. цэгт пассив сейсмийн, 1028 тууш.км хоёр хэмжээст чичирхийллийн ажил хийсэн.
6	Галба ХІ Зон Хэн Юу Тиан ХХК	2009.05.20	1316 тууш.км хоёр хэмжээст, 358.92 км ² талбайд гурван хэмжээст чичирхийллийн судалгаа хийж, хайгуулын 14 цооног өрөмдөж, 3 цооногт туршилт хийснээс 3 цооног тосны илрэл, 11 цооног тосны шинж тэмдэгтэй. Туршилтаар 1517 м ³ газрын тос олборлосон.
7	Сулинхээр ХХІІІ Шунхлай Энержи ХХК	2009.07.22	3993 физик цэгт хүндийн хүчний судалгаа, 6904 км соронзон хайгуул хийсэн. Одоо 480 тууш.км-т хоёр хэмжээст чичирхийллийн судалгаа хийж байна.
8	Борзон VІІ Импайр Газ Монголиа ХХК	2009.07.29	6102 физик цэгт хүндийн хүч, 470 тууш.км хоёр хэмжээст чичирхийллийн судалгааны ажил хийсэн. 1 цооногийн өрөмдлөгийн ажил хийгдэж байна.
9	Хөхнуур ХVІІІ “Эн Пи Ай” ХХК	2009.07.29	9861км ² талбайд хүндийн хүчний, 5470 физик.цэгт соронзон судалгаа, 2410.2 тууш.км хоёр хэмжээст чичирхийллийн ажил хийж, хайгуулын 5 цооног өрөмдсөн. 4 цооног тосны шинж тэмдэгтэй гарсан. 1 цооногт туршилтын ажил хийсэн.

10	Төхөм X (хойд) Сансарын геологи хайгуул ХХК	2009.07.29	Талбайн хэмжээнд микролептоны 1 ба 2-р шатны судалгаа, 5338 физик. цэгт хүндийн хүчний, 55242 физик.цэгт соронзон судалгаа, 1131 тууш.км хоёр хэмжээст чичирхийллийн ажил хийж, хайгуулын 2 цооног өрөмдсөн.
11	Цайдам XXVI Сансарын геологи хайгуул ХХК	2009.07.29	Талбайн хэмжээнд микролептоны 1 ба 2-р шатны судалгаа, 5126 физик. цэгт хүндийн хүчний, 38730 физик.цэгт соронзон судалгаа, 578.5 тууш.км хэмжээст хэмжээст чичирхийллийн ажил, 1 цооног өрөмдсөн.
12	Богд IV Капкорп Монголиа ХХК	2009.07.29	260 физик цэгт хүндийн хүчний судалгаа, 1670.6 тууш.км хоёр хэмжээст чичирхийллийн судалгаа хийж, стратиграфийн 1, бага гүнийн 2 цооног өрөмдсөн.
13	Онги V Капкорп Монголиа ХХК	2009.07.29	582 физик цэгт хүндийн хүчний судалгаа, 787.6 тууш.км хоёр хэмжээст чичирхийллийн судалгаа хийж, стратиграфийн 1 цооног өрөмдсөн.
14	Баянтүмэн XVII Магнай трейд ХХК	2010.12.08	2996 физик цэгт хүндийн хүчний, талбайн хэмжээнд соронзон судалгаа, 1072 тууш.км хоёр хэмжээст чичирхийллийн ажил хийсэн.
15	Дарьганга XXIV Апекспро инвестмент ХХК	2011.02.09	2278 физик цэгт хүндийн хүчний судалгаа, 210 тууш.км хоёр хэмжээст чичирхийллийн судалгаа хийсэн.
16	Төхөм X (урд) Монголын алт (МАК) ХХК	2012.07.25	17500 тууш.км соронзон судалгаа, 345.3 тууш.км хоёр хэмжээст чичирхийллийн судалгаа хийсэн.
17	Сүхбаатар XXVII Вульф петролеум ХХК	2013.01.02	23047 км ² талбайд геологийн зураглал, хүндийн хүч, соронзон судалгаа, 453 км тууш.км хоёр хэмжээст чичирхийллийн ажил хийсэн.
18	Номгон IX Сансарын геологи хайгуул ХХК	2014.02.07	БХГ-ний эрх үүргээ Өмнөд Монголын газрын тос/ӨМГТ/ компанид шилжүүлсэн. ӨМГТ компани 2015 оны ажлын төлөвлөгөөгөө батлуулсан. Хайгуулын ажил эхлээгүй байна.
19	Увс-I Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК	2015.04.20	2015.06.17-нд БХГ-нд гарын үсэг зурсан. 2 цооног өрөмдөх ажил хийгдэж байна.
20	Хар-Ус II Ренова Илч ХХК	2015.06.15	2015.07.05-нд БХГ-нд гарын үсэг зурсан. Хайгуулын тусгай зөвшөөрөл авах ажил хийгдэж байгаа.
21	Хэрлэнтохой-XXVIII Хонг Конг Вэлпэк Индастриал ХХК	2015.04.20	2015.05.12-нд БХГ-нд гарын үсэг зурсан. Хайгуулын тусгай зөвшөөрөл авах ажил хийгдэж байгаа.

ТОСОН-УУЛ, ТАМСАГИЙН ОРДЫН АШИГЛАЛТ, ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ТАНИЛЦУУЛГА



PetroChina


Гэрээлэгч:

“Дачин Ойл Фийлд Лимитед” компани нь БНХАУ болон дэлхийд томоохонд тооцогдох Хятадын Үндэсний Газрын Тосны Корпорацийн харьяа, гадаад зах зээлд бие даасан үйл ажиллагаа явуулах эрх бүхий төрийн өмчит компани юм. 2005 оны 8 дугаар сард Тосон-Уул XIX, Тамсаг XXI, Буйр XXII талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг АНУ-ын СОКО Интернейшнл компаниас шилжүүлэн авч, “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийг Монгол Улсад байгуулснаар дээрх талбайнуудад газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Хийгдсэн ажил:

Өрөмдлөг – 1175 кооног
2D – 10076 тууш км
3D – 4995.2 км²

Хөрөнгө оруулалт:
2,4 тэрбум ам.доллар
(1993-2014 он)



Газрын тосны нөөц:


Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн газрын тосны нөөцийг тооцоолж, АНУ-ын “DeGolyer and MacNaughton” (D&M) компаниар хөндлөнгийн үнэлгээ хийлгэсэн. ЭБЭХЯ-ны дэргэдэх ЭБМЗ-өөр 2010-2012 онуудад уг газрын тосны нөөцийн тооцооны тайлангуудыг хэлэлцүүлж, нөөцийг ЭБЭХ-ний сайдын тушаалаар Монгол Улсын Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд хүлээн авсан.

Эрх зүйн актууд:

Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам /ГТХХЖ/-ын 10.2-т заасны дагуу Тосон-Уул, Тамсагийн газрын тосны ордын ашиглалтын талбайн хэмжээг тогтоосон.

Засгийн газрын 2012.12.01-ний өдрийн 154 дүгээр тогтоолоор Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд ашиглалтын талбайн зөвшөөрөл олгосон.

ГТТХХЖ-ын 12.1 дэх заалт, БХГ-ний 5.4 дэх заалт, ЭБМЗ-ийн дүгнэлт, ЭБЭХ-ний сайдын тушаалыг үндэслэн Газрын тосны газрын даргын тушаалаар Тосон-Уул, Тамсагийн ордын ашиглалт эхлүүлэх зөвшөөрлийг Петрочайна Дачин Тамсаг ХХК-д олгосон.



Газрын тосны олборлолт, экспорт:

Монгол Улсын Их Хурал “2015 оны Төсвийн тухай хууль”-иар газрын тосны экспортын орлогоос улсын төсөвт 284,9 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр хэлэлцэн баталсан. Газрын тосны экспортын орлогыг бүрдүүлэхэд “Петрочайна Дачин Тамсаг” ХХК нь гол үүрэг гүйцэтгэдэг бөгөөд 2015 онд Тосон-Уул, Тамсагийн орд газраас нийт 7,36 сая баррель буюу 1 сая тонн түүхий тос олборлож, экспортлох төлөвлөгөөтэй ажиллаж байгаа ба 2015 оны 9 дүгээр сарын 16 -ний өдрийн байдлаар 5,57 сая баррель буюу 730,0 мянган тонн газрын тос олборлож, 5,24 сая баррель буюу 686,0 мянган тонн газрын тос БНХАУ-д экспортлоод байна.

Тамсагийн сав газраас олборлож буй түүхий тосыг Сингапурын бирж дээр худалдаалагддаг Платсын Дачин 33 маркийн тосны үнээс 1 ам.доллараар хямд үнээр борлуулдаг. 2015.09.15-ны байдлаар Пластын Дачин 33 маркийн тосны үнэ 38,16 ам.доллар/баррель байна.



Талбай буцаалт:


Буйр ХХII талбайн хайгуулын хугацаа 2010.01.30-ны өдөр дуусгавар болсон бөгөөд тус талбайг 2013.05.11-ний өдөр буцаан авсан.

Тосон-Уул, Тамсаг, Зүүнбаян Цагаан-Элсний ордын ашиглалтын талбайгаас гаднах талбайг буцааж авахад санал дүгнэлт гаргах ажлын хэсэг Уул уурхайн сайд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013.03.28-ны өдрийн 69/А-95 тоот хамтарсан тушаалаар байгуулагдсан. Тус ажлын хэсэг ажлын удирдамжийн дагуу холбогдох материалуудтай танилцан, талбай дээр ажиллаж, талбайг буцаан авахтай холбоотой албан шаардлагыг гэрээлэгч компаниудад хүргүүлж, гүйцэтгэлтэй танилцсан ба одоогоор холбогдох дүгнэлтийг гаргаж байна.

Газрын тосны ордын ил байгууламж, дэд бүтэц, эрчим хүч:

Петрочайна Дачин Тамсаг ХХК нь 2011 онд Тосон-Уул XIX талбайд Та-1 олборлолтын ил байгууламж, Дорнод аймгийн Чойбалсан хотоос Тосон-Уул XIX талбай хүртэл 110 кВ-ийн хүчин чадал бүхий 188,6 км цахилгаан дамжуулах агаарын шугам (ЦДАШ), 110 кВ-ийн дэд станц, Тосон-Уул XIX талбайгаас Бичигтийн хилийн боомтын чиглэлд 139 км сайжруулсан хайрган зам зэрэг дэд бүтцийн ажлуудыг барьж дуусган ашиглалтанд оруулсан ба 110 кВ-ийн дэд станцаас ЦДАШ-аар дамжуулан Матад сум цахилгаанаар хангагдаж, 139 км хайрган замаар газрын тосны экспортын тээвэрлэлт явагдаж байна.

2014 онд Тамсаг ХХI талбайд түүхий тос цуглуулах, цэвэршүүлэх, хадгалах, ачих, буулгах Та-2 олборлолтын ил байгууламжийг барьж дуусган, туршилтын журмаар ашиглалтанд оруулсан.



Тамсаг-XXI талбайд зөвхөн ослын үед нөөц хэлбэрээр ашиглах эрчим хүчний эх үүсвэрийг БНХАУ-аас татах асуудлаар холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулсан уулзалтыг 2013.01.21-нд ГТГ-т, 2013.11.08-нд ЭХЯ-д тус тус зохион байгуулсан. Уулзалтын үр дүнд Тосон Уул-ХИХ, Тамсаг-XXI талбайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд шаардагдах эрчим хүчийг "ДБЭХС" ТӨХК-иас тасралтгүй, найдвартай хангах талаар талууд харилцан тохиролцож, протокол байгуулсан. Тус протоколд тусгагдсаны дагуу Тосон-Уул XIX талбайгаас Тамсаг XXI талбай хүртэлх цахилгаан дамжуулах агаарын шугамыг 2015 онд багтаан барьж дуусган ашиглалтанд оруулах ба уг агаарын шугамын барилгын ажлыг 2014.09.26-ны өдөр эхлүүлсэн. Барилгын ажил гүйцэтгэгчээр "Илч Хангай" ХХК ажиллаж байгаа ба одоогийн байдлаар ажлын гүйцэтгэл 95 хувьтай байна.

Тамсаг-XXI талбайд ослын үе болон Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх хүртэл нөөц хэлбэрээр ашиглах эрчим хүчний эх үүсвэрийн асуудлаар 2013 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр Эрчим хүчний яам, Газрын тосны газар, Эрчим хүчний диспетчерийн үндэсний төв, "ДБЭХС" ТӨХК, "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн хооронд Протокол байгуулж, эрчим хүчний нөөц эх үүсвэр болох 35 кВ-тын ЦДАШ-ыг БНХАУ-аас барих нь зүйтэй гэж үзэн тохиролцсон. Одоогоор БНХАУ-аас татах 35 кВ-ын ЦДАШ-ын маршрут, Монгол-Хятадын хил нэвтрэх цэгүүдийг тогтоож, баталгаажуулах ажил дууссан ба зураг төслийг боловсруулах ажил хийгдэж байна.

Дээрх эрчим хүчний нөөцийн эх үүсвэрийг БНХАУ-ын Амгалангийн 220 кВ-ын дэд станцаас авах ба тэндээс Хятадын талд 121,4 км 110 кВ-ын ЦДАШ-аар 2 улсын хил хүртэл авчрах бөгөөд 110/35 кВ-ын дэд станцаар дамжуулан улсын хил нэвтрүүлэх юм. Харин Монголын нутаг дэвсгэрт баригдах 35 кВ-ын шугамын нийт урт 23,4 км байх юм. (Улсын хилээс Тамсаг XXI талбайн Та-2 олборлолтын ил байгууламж хүртэл)

Авто зам:

Тосон-Уул XIX талбайн үйлдвэрлэлийн баазаас Баянхошуу-Өвдөгийн хилийн боомт чиглэлийн 210,7 км хатуу хучилттай авто замыг 4 багцад хуваан барилгын ажлыг гүйцэтгэх ба эхний 2 багцын нийт 104 км автозамыг БНХАУ-ын Дачин Ойлфийлд зам гүүрийн компаниар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан 1, 2 дугаар хэсгийн барилгын ажлыг 2013 оны 8 дугаар сард эхлүүлсэн ба 2015 онд багтаан дуусгах юм. Тус авто замын 4 дүгээр багцын барилгын ажил гүйцэтгэгчээр Монгол улсын аж ахуйн нэгж шалгарч, гэрээ байгуулсан ба одоогоор 52 км суурийн даланг хийж байна. Харин 3 дугаар багцын барилгын ажил гүйцэтгэгчийг Монгол улсын аж ахуйн нэгжүүдээс сонгон шалгаруулахаар монголын авто замын компаниудтай хэлэлцээр хийж байна.

Газрын тосны орд ашиглалт:

Петрочайна Дачин Тамсаг ХХК нь Тосон-Уул, Тамсагийн газрын тосны орд ашиглах төлөвлөгөөг ГТГ-ын Хайгуул, ашиглалтын техникийн зөвлөлөөр хэлэлцүүлж, ГТГ-ын даргын 125 дугаар тушаалаар батлуулсан.

Тосон-Уулын газрын тосны ордын ашиглалтын хугацаанд нийт 1638 цооног (үүнээс 1171 газрын тосны олборлолтын цооног, 467 ус шахалтын цооног), нийт 57 усны эх үүсвэрийн цооног, Та 1-15, Та 1-23 цуглуулах, дамжуулах станц, гүний усыг цэвэршүүлэх станц, Баянхошуу хилийн боомтын чиглэлд 210,7 км хатуу хучилттай авто зам, ажилчдын амьдарч, ажиллах үйлдвэрлэлийн суурин, 17 ш 500 кВт-ын хийн цахилгаан үүсгүүр зэргийг барьж ашиглалтанд оруулж 2039 он хүртэл 20,17 сая тонн тос олборлоно.

Тамсагийн газрын тосны ордын ашиглалтын хугацаанд нийт 1136 цооног (үүнээс газрын тосны олборлолтын 842 цооног, ус шахалтын 294 цооног), нийт 38 усны эх үүсвэрийн цооног, Тосон-Уул XIX талбай - Тамсаг XXI талбайн хооронд 100 кВт-ын 100 км цахилгаан дамжуулах агаарын шугам, Та-2 олборлолтын ил байгууламжаас Тосон-Уул XIX талбай - Баянхошуу боомтын чиглэлийн автозамд нийлэх 60 км хатуу хучилттай автозам, ажилчдын амьдарч, ажиллах үйлдвэрлэлийн суурин, ус зайлуулах, гал түймэртэй тэмцэх байгууламж, 4000 кВт-ын 4 ш дизель генератор, 4 ш 500 кВт-ын хийн цахилгаан үүсгүүр, хатуу хог хаягдлыг боловсруулах байгууламж, шатахуун түгээх станц зэргийг барьж ашиглалтанд оруулж, 2041 он хүртэл нийт 21,01 сая тонн түүхий тос олборлоно.

2015 онд Тосон-Уул XIX талбайн 50 цооногийн өрөмдлөг, Т1-9 дамжуулах станцын өргөтгөл, Т1-11 дамжуулах, цэвэршүүлэх станц, Баянхошууны хилийн боомт хүртэлх замын 3 ба 4 хэсэг, Тамсаг-XXI талбайн 80 цооногийн өрөмдлөг, ШТС, 110 кВ-ын дэд станц болон Тосон-Уул XIX талбайгаас Тамсаг XXI талбай хүртэлх 110 кВ-ын ЦДАШ зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн нийт 510 сая ам.долларын хөрөнгө оруулахаар төлөвлөж байна.

Ажиллах хүч:

Засгийн газрын 2009.02.18-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор газрын тос, байгалийн хийн хайгуул болон олборлолтын үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай компанийн 501 сая төгрөгөөс дээш дүрмийн сантай, мөн нийт ажиллагсадын тоо 501-ээс дээш тохиолдолд 80 (гадаад) : 20 (монгол) гэж гадаад мэргэжилтэний эзлэх хувийг тогтоож байсан. Энэ нь Засгийн газрын 2015.01.07-ны өдрийн 2 дугаар тогтоолоор газрын тос, байгалийн хийн хайгуул болон олборлолтын үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай компанийн нийт ажиллагсадын тоо 251-ээс дээш тохиолдолд 75 (гадаад):25 (монгол) гэж гадаад мэргэжилтэний эзлэх хувийг тогтоохоор болж шинэчлэгдсэн.

2013 онд: Засгийн газрын 2013 оны 192,184, 32 дугаар тус тус тогтоолоор нийт 2440 инженер, техникийн мэргэжилтэн, ажилтануудад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг олгож, Засгийн газрын 2013.12.21-ний 58 дугаар тэмдэглэлээр 695 гадаад ажилтануудын сунгалтыг олгосон.

2014 онд: Засгийн газрын тогтоолоор 2014 онд гадаадаас ирэх ажиллах хүчний зөвшөөрлийг гурван удаа тухай бүр оруулж ирэхээр тогтоож, тус зөвшөөрлийг нийт 2841 иргэнд гаргуулж байснаас 2276 гадаад иргэд хөдөлмөр эрхэлсэн.

2015 онд: Засгийн газрын 2014 оны 403, 2015 оны 75, 165 дугаар тогтоолоор Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн Тосон-Уул, Тамсагийн сав газарт ажиллах нийт 2631 гадаад мэргэжилтэнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг тус тус олгоод байна.

ЗҮҮНБАЯН, ЦАГААН-ЭЛСНИЙ ОРДЫН АШИГЛАЛТ, ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР ТАНИЛЦУУЛГА





Гэрээлэгч:

БНХАУ-ын “Доншен Жингүн Петролеум Дивилопмент Групп Сток” компани нь Австралийн Рок Ойл (Говь) компаниас 2003 оны 2 дугаар сарын 15-нд Монгол Улсын Засгийн газрын 1997.02.19-ний өдрийн 47 тоот тогтоолоор батлагдсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлэн авч, БНХАУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай Доншен газрын тос (Монгол) ХХК-ийг Монгол Улсад байгуулан газрын тостой холбогдсон үйл ажиллагааг явуулж эхэлсэн.

Хийгдсэн ажил:

Өрөмдлөг – 119 цооног
2D – 5138,8 тууш км
3D – 339,6 км²

Хөрөнгө оруулалт:
250,1 сая ам.доллар
(1994-2014 он)



Газрын тосны нөөц:

БНХАУ-ын Шенлигийн газрын тосны удирдах товчооны Геологийн эрдэм шинжилгээний хүрээлэн 1997 оны БХГ-т талбайн ТЕ-14 (Цагаанцав), ТЕ-1 (Шинэхудаг), ТЕ-27 (Шинэхудаг), ZB (Цагаанцав), SWZB (Цагаанцав), EZB-1 (Цагаанцав), EZB-4 (Цагаанцав) ба WTE-1 (Цагаанцав) блокуудын нөөцийн тооцооны тайланг боловсруулсан.


ЭБЭХЯ-ны дэргэдэх ЭБМЗ-өөр 2010-2012 онуудад уг газрын тосны нөөцийн тооцооны тайлангуудыг хэлэлцүүлж, нөөцийг ЭБЭХ-ний сайдын тушаалаар Монгол Улсын Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд хүлээн авсан.

Эрх зүйн актууд:

Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам /ГТХХЖ/-ын 10.2-т заасны дагуу Тосон-Уул, Тамсагийн газрын тосны ордын ашиглалтын талбайн хэмжээг тогтоосон.

Засгийн газрын 2012.12.01-ний өдрийн 154 дүгээр тогтоолоор Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд ашиглалтын талбайн зөвшөөрөл олгосон.


ГТТХХЖ-ын 12.1 дэх заалт, БХГ-ний 5.4 дэх заалт, ЭБМЗ-ийн дүгнэлт, ЭБЭХ-ний сайдын тушаалыг үндэслэн Газрын тосны газрын даргын тушаалаар Тосон-Уул, Тамсагийн ордын ашиглалт эхлүүлэх зөвшөөрлийг Доншен газрын тос (Монгол) ХХК-д олгосон.



Газрын тосны олборлолт, экспорт:

Монгол Улсын Их Хурал “2015 оны Төсвийн тухай хууль”-иар газрын тосны экспортын орлогоос улсын төсөвт 284,9 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр хэлэлцэн баталсан. Газрын тосны экспортын орлогыг бүрдүүлэхийн тулд 2015 онд 1997 оны БХГ-т талбайгаас нийт 357 000 баррель буюу 50 000 тонн газрын тос олборлож экспортлох төлөвлөгөөтэй ажиллаж байгаа ба 2015 оны 9 дүгээр сарын 16-ний өдрийн байдлаар 325944 баррель буюу 45587 тонн газрын тос олборлож, 282633 баррель буюу 39529 тонн газрын тос БНХАУ-д экспортлоод байна.

Зүүнбаян, Цагаан-Элсний ордоос олборлож буй түүхий тосоо Лондонгийн бирж дээрх “DTD Brent” маркын тосны тухайн үеийн борлуулах үнээс 3,62 ам.доллар хассан үнээр борлуулдаг ба Brent маркийн тосны үнэ 2015.09.15-ны байдлаар 45,940 ам.доллар/баррель байна.




Талбай буцаалт:

1997 оны БХГ-т талбайд 2010 оны 6 дугаар сарын 14-нд хайгуулын хугацаа дуусгавар болсон. Уул уурхайн сайд болон БОНХ-ийн сайд нарын 2013.03.28-ны өдрийн хамтарсан тушаалаар байгуулагдсан талбайг буцаан авахад дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг 2014 оны 3 дугаар сарын 18-ны өдөр “Доншен газрын тос (Монгол) ХХК нь ажлын хэсгийн тавьсан шаардлагыг холбогдох стандарт, дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэсэн тул уурхайн эдэлбэрээс гаднах 5038,7 км² талбайг Монгол Улсын Засгийн газар хүлээн авах боломжтой” гэж дүгнэлт гаргасан.

Газрын тосны ордын ил байгууламж, дэд бүтэц, эрчим хүч:

Дорноговь аймгийн Зүүнбаян багаас газрын тосны ордын ашиглалт явуулах талбай хүртлэх 35 кВ-ийн 21 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 5МВт-ын дэд өртөө хуваарилах байгууламж, 35/6 кВ-ийн дэд станцын өргөтгөл, 6кВ-ийн 38 км цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажлыг “Багануур ЗӨБЦТС” ТӨХК-иар гүйцэтгүүлж ашиглалтанд оруулсан.

Үйлдвэрлэлийн баазын үйл ажиллагаанд ашиглагдах 17 том, 6 бага оврын автомашины дулаан зогсоол, Зүүнбаян дахь үйлдвэрлэлийн бааз болон Цагаан-Элсний олборлолтын талбайд ажилчдын амьдрах байр, албан конторын барилга, ус шахалтын байгууламж, тэсрэх бодисын агуулах, ШТС зэргийг Монгол Улсын холбогдох стандартын дагуу барьж ашиглалтанд оруулсан.



Газрын тосны ордын ашиглалт явуулах талбайгаас түүхий тос хадгалах танк фарм хүртлэх 22,7 км сайжруулсан хайрган замыг “Хурдны зам” компаниар гүйцэтгүүлж ашиглалтанд хүлээн авсан. Одоогоор энэхүү замыг хатуу хучилттай автозам болгохоор Монгол Улсын “Сайнгэрэлт” ХХК-иар зураг төслийн ажлыг хийлгэж, экспертизийн дүгнэлт гаргуулан “Дорноговь АЗЗА” ТӨХК барилгын ажлыг эхлүүлж, 10 км-ийг хатуу хучилттай асфальтан зам болгон ашиглалтанд оруулсан.

Зүүнбаян баг дахь үйлдвэрлэлийн баазад өвлийн улиралд тосыг уураар халаах зориулалттай цагт 4 тн уур гаргах хүчин чадал бүхий уурын зуух, мөн нэг удаагийн ачилтаар 32 ш вагонцистернд зэрэг ачилт хийх чадалтай 400 м урттай вагонцистернд тос ачих байгууламж, түүхий тос хадгалах, цэвэршүүлэх, ачих, буулгах ил байгууламж, 400м³-ийн багтаамжтай 4 ш, 700м³-ийн багтаамжтай 6 ш, 1000м³-ийн багтаамжтай 6 ш, нийт 11200 м³ буюу 76738 баррель (10732 тонн) тос хадгалах танк фарм, олборлолтын талбайд цооногуудын дэргэд 50м³-ийн багтаамжтай 90 ш, 200м³-ийн багтаамжтай 4 ш, 300м³-ийн багтаамжтай 64 ш нийт 24500 м³ буюу 132000 баррель (18470 тонн) тос хадгалах сав зэргийг барьж ашиглалтанд оруулан, 42 ш шинэ вагонцистернийг ОХУ-аас худалдан авч түүхий тосны тээвэрлэлтэнд ашиглаж байна.

Газрын тосны орд ашиглалт:

Зүүнбаян, Цагаан-Элсний газрын тосны ордын ашиглалтын хугацаанд нийт 171 цооног (шинээр 66 цооног өрөмдөх), нийт 8 усны эх үүсвэрийн цооног, Цагаан-Элс ордоос Зүүнбаянгийн тос хадгалах танк фарм хүртэл 22,7 км хатуу хучилттай автозам барих, 2 ус шахалтын станц, гүний усыг гүн цэвэршүүлэх станц зэргийг барьж ашиглалтанд оруулж, 2012-2030 оны хооронд нийт 8,34 сая баррель буюу 1,16 сая тонн түүхий тос олборлоно.

2015 онд 1997 оны БХГ-т талбайн 8 цооног өрөмдөх, 18 цооног олборлолтонд шилжүүлэх, 12,7 км хатуу хучилттай авто зам барих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн нийт 27,3 сая ам.долларын хөрөнгө оруулахаар төлөвлөж байна.

Ажиллах хүч:

Засгийн газрын 2009.02.18-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор газрын тос, байгалийн хийн хайгуул болон олборлолтын үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай компанийн 501 сая төгрөгөөс дээш дүрмийн сантай, мөн нийт ажиллагсадын тоо 501-ээс дээш тохиолдолд 80 (гадаад):20 (монгол) гэж гадаад мэргэжилтэний эзлэх хувийг тогтоож байсан. Засгийн газрын 2015.01.07-ны өдрийн 2 дугаар тогтоолоор газрын тос, байгалийн хийн хайгуул болон олборлолтын үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай компанийн нийт ажиллагсадын тоо 251-ээс дээш тохиолдолд 75 (гадаад):25 (монгол) гэж гадаад мэргэжилтэний эзлэх хувийг тогтоохоор болж шинэчлэгдсэн.

2013 онд: Засгийн газрын 2013 оны 192 дугаар тогтоолоор нийт 250 инженер, техникийн мэргэжилтэн, ажилтануудад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг олгож байсан.

2014 онд: Засгийн газрын тогтоолоор 2014 онд гадаадаас ирэх ажиллах хүчний зөвшөөрлийг 250 байхаар тогтоож, тус зөвшөөрлөөр Монгол Улсын хилээр орж ирсэн 192 гадаад иргэд хөдөлмөр эрхэлсэн.

2015 онд: Засгийн газрын 2014 оны 403, 2015 оны 75 дугаар тогтоолоор Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн Зүүнбаян, Цагаан-Элсний сав газарт ажиллах нийт 297 гадаад мэргэжилтэнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг тус тус олгоод байна.

ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР